



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.09 № 05/571  
тачай -ны № -т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газрын Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн Орон зайн өгөгдлийн стандартчилал, боловсруулалт хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Чинбатын Чимэгбаяр, Хот байгуулалтын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Амгалангийн Энхнаран, Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Дэндэвийн Энхтуяа, Кадастрын хэлтсийн Газрын кадастрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Түмэнжаргалын Тамир, Хот байгуулалтын хэлтсийн Хот суурины инженерийн бэлтгэл арга хэмжээ, гамшгаас хамгаалах орон зайн төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Цогтбаярын Анар, Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн Хот, тосгон, бусад суурины газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Энхбаярын Сайнтөр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн Урсгал үйл ажиллагааны бүртгэл, тайлагнал хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Дуламын Энхтуул нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Н.ДАМДИНСҮРЭН



142403000333



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сүүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.23 № 05/1470.  
тэ най -ны № -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА А.ЭНХМАНЛАЙ  
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Газар зохион байгуулалт, зураг зүйн ерөнхий газрын Хяналт шалгалтын хэлтсийн Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Даваажанцангийн Бямбадулам, Бат-Өлзийн Наранцэцэг, Газар зохион байгуулалтын хэлтсийн сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Шархүүгийн Дащондог нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Н.ДАМДИНСҮРЭН



142466001199



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.01.26 № 05/1737  
тачай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА А.ЭНХМАНЛАЙ  
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн орон зайн өгөгдлийн сангийн удирдлагын систем, технологийн шийдэл хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилогодооор нэр дэвшсэн Тэгшээбаатарын Оюунтөгс, Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогодооор нэр дэвшсэн Амарбаярын Жавхлан нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч А.Жавхлан нь өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, авто машин түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Би энд Жи потенциал” ББН-ийн 90% хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, гүйцэтгэх захирлаар бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллана уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142403001409